

БАТЛАВ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА
Д.ЦОЛМОН

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1 Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын жишиг бодлого, Эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасны дагуу ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх

1.2 Ажилтан албан хаагчийн гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд чиглэсэн сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах, байгууллагын нөөц, байгууллагын онцлогт нийцүүлэн хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллана.

Хоёр. Үндсэн зарчмууд

2.1 Хүүхдийн эрх, язгуур эрх ашиг, тэдний аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч хүндэтгэн үзнэ.

2.2 Хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй.

Гурав. Хамрах хүрээ

3.1 Байгууллагын ажилтан албан хаагч

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1 Байгууллага ажил олгогч нь ажилтны ажил амралтын цагийг зохицуулах, хөдөлмөрийн харилцааны уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны амьдралын тэнцвэрийг хангах

4.2 Байгууллагад Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын жишиг бодлого, Эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмжийн дагуу Эцэг эхийн зөвлөл байгуулах

4.2.1 Зөвлөлийн дарга төлөвлөгөөгөө хамт олноор хэлэлцүүлж, байгууллагын даргаар батлуулах, биелэлтийг удирдлага, хамт олонд танилцуулах

4.2.2 Байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудаст хүүхэд хамгааллын бодлоготой холбоотой баримт, мэдээллийг байршуулан сурталчлах

4.2.3 Байгууллагын ажилтан албан хаагч нарын гэр бүл, хүүхдийн нөхцөл байдлын судалгаа хийж, хэрэгцээнд нь тулгуурлан сургалт зохион байгуулах, бодит дэмжлэг үзүүлэх

4.2.4 Ажилтан албан хаагч нарын гэр бүл, хүүхдэд чиглэсэн нөлөөллийн сургалтыг зохион байгуулах

4.3 Байгууллага хамт олноороо хүүхэд ээлтэй байгууллага болох санаачилгыг өрнүүлэх

4.4 Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ажилтан, албан хаагч тэдний гэр бүл, хүүхдэд зориулсан соён гэгээрүүлэх хөгжүүлэх чадавхжуулах сургалт, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулах

4.5 Байгууллага нь нөөц боломждоо тулгуурлан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх

4.5.1 Хүүхдийн хөгжих эрүүл аюулгүй, хараа хяналттай байхад анхаарч хүүхдийн өрөөтэй болох

4.5.2 Байгууллагын гадаад дотоод орчны эрсдэлийн үнэлгээ хийх, илэрсэн эрсдэлийг арилгах арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд эрсдэлт нөхцөл байдлыг холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэх

Тав. Ажилтан албан хаагчийн хориглох зүйл

5.1.1 Хүүхдийг цохих зодох, тусгаарлах зэргээр бие махбодын хүчирхийлэл үйлдэхгүй байх

5.1.2 Хүүхдийг гутаах, ичээх доромжлох, дорд үзэх, нэр хоч өгөх, сэтгэл зүйн дарамт учруулах зэргээр сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх

5.1.3 Хүүхдийн дэргэд хараал хэлэх бүдүүлэг үг хэллэг ашиглах

5.1.4 Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, аюултай нөхцөл, байдалд орсон тохиолдолд мэдээлэхгүй орхих

Зургаа. Байгууллагын хориглох зүйл

6.1 Байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг зөрчиж байгаа нь мэдэгдсэн сэжиглэгдсэн боловч мэдээгүй мэт өнгөрөөх нуун дарагдуулах